

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР




САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/08/-НА-СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга	
	Дарга, Тэргүүлэх аудитор:	Х.Түвшинбаяр
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Ж.Бүжинханд
	Утас: 70484030	Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	7
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	8
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ОНТС	Орон нутгийн төсөл сан
НА	Нийцлийн аудит



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.АВИРМЭД ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.29 № 23
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07922180

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	211,443,356.20	215,173,267.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	47,871,178.20	29,929,720.20
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	47,871,178.20	29,929,720.20
31210	Төгрөг	47,871,178.20	29,929,720.20
31211	Төрийн сангийн харилцах	47,871,178.20	29,929,720.20
33	АВЛАГА	148,359,178.00	170,030,547.00
33400	Зээлийн хүүгийн авлага	1,008,857.00	577,042.00
33600	Зээлийн авлага	147,350,321.00	169,453,505.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	147,350,321.00	169,453,505.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	147,350,321.00	169,453,505.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,213,000.00	15,213,000.00
35100	Түүхий эд материал	15,213,000.00	15,213,000.00
35110	Тусгай зориулалттай материал	15,213,000.00	15,213,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	211,443,356.20	215,173,267.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	40,050.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	40,050.00
41300	Өглөг	0	40,050.00
41360	Бусад өглөг	0	40,050.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	40,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	211,443,356.20	215,133,217.20
51	Засгийн газрын хувь оролцоо	211,443,356.20	215,133,217.20
51200	Хуримтлагдсан үр дүн	211,443,356.20	215,133,217.20
51210	Өмнөх үеийн үр дүн	207,900,531.25	211,443,356.20
51220	Тайлант үеийн үр дүн	3,542,824.95	3,689,861.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	211,443,356.20	215,173,267.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,998,824.95	4,209,861.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,998,824.95	4,209,861.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,998,824.95	4,209,861.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,998,824.95	4,209,861.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,682,510.00	4,192,390.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	316,314.95	17,471.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	456,000.00	520,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,000.00	520,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,000.00	520,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	456,000.00	420,000.00
210401	Бичиг хэрэг	150,000.00	0
210402	Тээвэр, шатахуун	306,000.00	420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	100,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,542,824.95	3,689,861.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,542,824.95	3,689,861.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	207,900,531.25	207,900,531.25
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,900,531.25	207,900,531.25
9	Тайлант үеийн үр дүн	3,542,824.95	3,542,824.95
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,443,356.20	211,443,356.20
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,443,356.20	211,443,356.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,443,356.20	211,443,356.20
19	Тайлант үеийн үр дүн	3,689,861.00	3,689,861.00
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	215,133,217.20	215,133,217.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	65,342,789.00	76,578,542.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,342,789.00	76,578,542.00
120	Нийтлэг татварын бус орлого	65,342,789.00	76,578,542.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,342,789.00	76,578,542.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,342,587.00	76,283,492.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	202	295,050.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	456,000.00	520,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,000.00	520,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,000.00	520,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	456,000.00	420,000.00
210401	Бичиг хэрэг	150,000.00	0
210402	Тээвэр, шатахуун	306,000.00	420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	100,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	64,886,789.00	76,058,542.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-69,500,000.00	-94,000,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	69,500,000.00	94,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	69,500,000.00	94,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-4,613,211.00	-17,941,458.00
101	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	52,484,389.20	47,871,178.20
20	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,871,178.20	29,929,720.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,900,000.00	94,520,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,950,000.00	520,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,950,000.00	520,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,070,000.00	420,000.00
210401	Бичиг хэрэг	0	0
210402	Тээвэр, шатахуун	1,070,000.00	420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	780,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	780,000.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	94,950,000.00	94,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	94,950,000.00	94,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,900,000.00	76,578,542.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	96,900,000.00	76,578,542.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,950,000.00	76,283,492.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,950,000.00	295,050.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,000,000.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	47,871,178.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	29,929,720.20

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сан нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам” батлагдсан. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд

санхүүгийн дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар журамлагдсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол банкны мэдээллийн системд Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчийн зээлийн мэдээллийг оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд сангаас олгосон зээл нь 3 жил төлөгдөхөөр авлага үүсгэж байгаа тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүн болох 211.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 215.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сангийн хөрөнгийг сумдад жижиг дунд үйлдвэрлэл шинээр байгуулах буюу үйл ажиллагааг өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар байна.

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх санд оны эхэнд 47.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 76.6 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлого орж, 94.0 сая төгрөгийн зээл нэмж олгосон байна. Тайлант хугацаанд хяналтын шатахуун, программын зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан ба оны эцэст дансандаа 29.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу мөнгөн хөрөнгө 59.0 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын эхний үлдэгдэл 148.4 сая төгрөг байсан бол тайлант хугацааны эцэст 170.0 сая төгрөг болж 21.6 сая төгрөгөөр өссөн нь нэмж зээл олгосонтой холбоотой.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 215.1 сая төгрөг болж 3.7 сая төгрөгөөр өссөн нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүүгийн орлогыг тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэгтэй холбоотой. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сум хөгжүүлэх сангийн тухайд төсвийн төсөл хийгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сангийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй нь холбоотой жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2021 онд 96.9 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Төсвийн гүйцэтгэлээс үзэхэд үндсэн зээлийн болон хүүгийн орлогын төлөвлөгөөг 9.6 сая төгрөгөөр давуулсан нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сум хөгжүүлэх санд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг

санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Сум хөгжүүлэх сангийн 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээлжээ. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь сангийн үйл ажиллагаанд 2012 онд гүйцэтгэлийн аудит, 2014, 2018 онд нийцлийн аудит, 2014 оноос хойш жил бүр санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийсэн.

Өмнөх аудитаар нийт 182.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 158.1 сая төгрөгийг төлүүлж, 24.0 сая төгрөгийн авлагад Шүүхийн шийдвэр гаргуулан шийдвэрийн үлдэгдэлгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар зээлдэгчийн авлагын дэлгэрэнгүй тайлан, тооцоо нийлсэн акт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, гэрээ, гэрээний хэрэгжилт, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үзэх нь зүйтэй.

Мөн олон жил ашиглагдаагүй 15.2 сая төгрөгийн оёдлын тоног төхөөрөмж бараа материалд бүртгэлтэй байгаа бөгөөд хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж эргэлтэд оруулах шаардлага бий болж байна. Үүнийг төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар үзэх хэрэгтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй, 6.2 сая төгрөгийн алдааг залруулсан.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 6.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

4.4 Зөвлөмж

Аудитаар менежментийн захидал өгсөнгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Сум хөгжүүлэх сан	1	6.2	1	6.2						